

**“Ёст хаан Юн Ло”-гийн домгийн
аман хувилбарууд**

Р.Чултэмсүрэн (Dankook University)▼

1. Оршил

Монголын эрдэмтэн Ш.Гаадамба монголын түүхэн сурвалжуудаар уламжлагдан ирсэн “Ёст хаан Юн Ло”-гийн домгийг судалсан¹ билээ. Энэ домгийг Палладий Кафаров (1886) “Монголын Нууц Товчоо” зохиолын орос орчуулгын оршилд дурдаж, Л.С. Пучковский² (1958) зэрэг эрдэмтэд түүхийн үүднээс судалсан тухай Ш.Гаадамба багш тэмдэглэсэн. Мөн Хятад, Япон, Герман³ зэрэг улсад эртнээс Юн Ло (Yung Lo) хааны тухай өргөн судалжээ.

“Ёст хаан Юн Ло”-гийн домогтой төстэй “Юан тайж Жин тайж хоёр” хэмээх аман домгийг А.Мостерт (A.Mostaert⁴) Ордос нутгаас сурвалжлан тэмдэглэж хэвлүүлсэн байна. Мөн Ордосын ахмад үлгэрч Чогров⁵ “Юан тайшийн үлгэр”-ийг хэлж бичүүлжээ. Энэхүү хоёр зохиол

▼ (Улсын Багшийн Их Сургуулиас уригдан ажиллаж байгаа багш)

¹ Ш.Гаадамба, *Ёст хаан Ён-Логийн (Юн-Логийн) домог, Монголын Нууц Товчооны судлалын зарим асуудал*, УБ., 1990, 188-190.

² *Ученные записки института востоковедения*, Том-VI, М., Л., 1958, 145 гэж Монголын уран зохиолын тойм (1977)-ын хоёрдугаарт бичсэнийг дам ишлэв.

³ Franke, W., *Chinesische Feldzüge durch die Mongolei im jruhen 15. Jahrhundert*. In *Sinologica* Vol. 3, Basel, 1953.

⁴ *Arj Borj qayan, Ündüsüten-ü keblel-ün qoriya-a, Yuwan tayij jng tayij qoyar*, A.Mostaert *öuyayulun emkidkebe*, 1989, 269-277.

⁵ *Aqamad üligerä Çorob-un yariyan üliger-üd, Yuwan tayisi-yin üliger*, *Ordus-un Soyul-un öb* (4), 1989, 10.1.83-88.

бол дээр дурдсан бичгийн "Ёст хаан Юн Ло"-гийн домгийн аман хувилбар байна гэж бид үзэж байна. "Ёст хаан Юн Ло"-гийн домгийг өмнөх судлагчид судалсан боловч харин энэхүү аман хувилбаруудын талаар түүх, аман зохиол судлалд төдийлөн дурдсан зүйл байхгүй байх шиг байна. Иймд энэхүү бяцхан өгүүлэлд дээрх бичгийн болон аман түүхэн домгуудыг аман ба бичгийн зохиолын харьцаанд нь харьцуулж, ажиглан үзэх зорилго тавин, оролдлоо⁶.

2. "Ёст хаан Юн Ло"-гийн домгийн тухай

2.1 Бичгээр уламжилсан "Ёст хаан Юн Ло"-гийн домгийн гол өгүүлэмж:

1) "Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршивай"-д:

Бичгээр уламжлан ирсэн энэхүү домгийг Өвөр Монголын эрдэмтэн Чойжи (Choyizhi)-ийн тулган харьцуулж тайлбарласан, *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршивай*⁷ зохиолын (цаашид *Лу.Алтан товч* хэмээн дурдах болно) 292 дугаар зүйлийг үндэслэн агуулгыг нь товчлон дурдъя.

Тогоонтөмөр хааны төр автагдахад Хонкирад (Hongkirada) хатан нь гурван сартай хөл хүнд олзлогдоно. Хатныг хятадын Жоу Хонхуа (Zhou Honghu-a) авч хан оронд суув.

Хатан хүүгээ долоон сар болж төрвөл дайсных гэж ална. Арван сар болж төрвөл өөрийн үр гэж бодно гэж бодоод гурван сар нэмж арван сар болгон, нуган хөвүүн төрүүлж өршөөн соёрх гэж тэнгэрт залбиран гуйна. Тийнхүү тэнгэрт залбирсаны ачаар арван гурван сар болж, хатнаас хүү төрөв. Удалгүй бас тэр хааны хятад хатнаас нэгэн хөвүүн төрөв. Нэгэн шөнө хаан "Хоёр луу хэрэлдэж, баруун лууг зүүн луу дийлэв" хэмээн зүүдэлнэ. Зүүдийг ёрчиноос асуухад, "баруун луу гэгч хятад хатны хөвгүүн. Зүүн луу гэгч монгол хатны хөвгүүн. Чиний хан орон дор суух гэж байна" хэмээн тайлна. Хаан ялгалгүй үр минь мөн боловч эх нь дайсны хатан. Үүнээс төрсөн хөвгүүн миний хан ор сууваас муу болно хэмээн сэжиглэж, монгол хатны хүүг ордноос гаргаж, хэрмийн гадна Хөх хот барьж суулгав. Хонхуа хаан их ор сууж, 31 жил болоод үгүй болов. Түүний хөвгүүн Жажур-а (Zhahur-a) хаан хан оронд сууж, дөрвөн он болсны хойно Хонкирээд хатны хөвгүүн Юн-ло хаан цэрэглэн ирж, Хятадын Хонхуа хааны хүү Жажур-а хааныг барьж, хүзүүнд нь мөнгөн тамга дарж, оронд нь хаан болно. Хятад улс түүнийг ёст хаан Их Мин Юн Ло хаан гэж өргөмжлөв. Юн Ло хаан хүчин тусалсан нөхдийг шагнан, 22 жил хаан суугаад тэнгэр болов. Түүний үр 11 үе хаан суусан гэж *Лу. "Алтан Товч"*-ид нэрийг нь жагсаан дурджээ.

⁶ Өмнө нь миний бие "Юан гүрний үед холбогдох нэгэн домгийн тухайд" хэмээх өгүүлэл бичиж, БНСУ-ын "Монгол судлал" (Mongolian Studies) сэтгүүлд (2003, 15, 157-179)-д нийтлүүлснээ дахин засаж, товчлон нийтлүүлж байгаа болно.

⁷ *Altan tobči, Čoyiži tulyan qančayulju tayilburilaba, Öbür Mongyol-un Arad-un keblel-ün qorigi-a*, 1984. 550-554.

2) "Эрдэнийн эрхи" зохиолд:

Энэ зохиолын өгүүлэмж дээрхи түүхэн сурвалжтай адил төстэй боловч Бээжинд хоцорсон хонгирад хатан мөн Тогоон Төмөрөөс гурван сартай хөл хүнд үлдсэн. Хятадын Жүгэ хэмээх⁸...хаан ор суусан гэх зэргээр он, жил, хүний нэр сэлтийг дэлгэрэнгүй дурджээ.

3) "Монгол орноо шашин төр тогтсон ёсыг сайтар өгүүлсэн тунгалаг ухаант залуусын хоолойн чимэг тунамаг гэрэлт алтан эрхи" буюу олноо "Алтан эрхи" хэмээн алдаршсан зохиолд:

Юн Ло хаан нь ухаант хааны хөвгүүн хэмээх нь: Нэгэн хуучны түүхэнд Шүн Ди ухаант хааны нэгэн хатан нь Хонгирадын Тогтага тайшийн охин Гэрэлтэй бие шалтгаантай долоон сар болох хэрд Шүн Ди хаан гадагш зугатааж одоход тэр хатан тэндээ хоцорсныг...Хун Эү хан биедээ аваад гурван сар болж төрсөн хөвгүүнийг хожим хятадын түшмэд хэлэлцэж, "энэ хөвгүүн монголын үр тул хойно манай хятад улсыг өслөх болзоо үгүй" хэмээн ахмад хөвгүүн боловч хаан болгол үгүй нөгөө хөвгүүнийг хан орноо суулгасан. Тэрбээр үр үгүй өнгөрсний тул урьдах монгол ханы хөвгүүн хаан суусан нь Ян ван Юн Ло болой...Дай Мингийн Ян вангаас дараалсан хаадууд мөнхүү монгол хаадын ач үр мөн амой⁹..." гээд уг номонд Юн Ло-оос хойших Дай Мин хаад хэмээн тодорхой дурдсан байна.

4) "Бурядад түүхэ бэшэгүүд"¹⁰ хэмээх шастирт:

Чингис хаагаа Тогоон Түмэр хүрэтэр 15 үе болоно. Дайминг хотонһоо Тогоон Түмэр хаан 51 наһандаа хас тамга, **Гунжалан хатанаа**, хүүхэдээ абажа, 7 нүхэдтэйгөө гараад, Хэрлэн мурэнэй хизаар ерэжэ, Барас хот барижа, 6 түмэн монголшуудые эзэлэн хаан боложо нууба...Тогоон Түмэр хаанай түрые 1367 ондо буляан абаһан Хитадай ехэ ноён Даймин Юхунва хэмээн алдаршаба.Тогоон Түмэр хаанай 3-дугаар хатан **Гэрэлтэ** хэмээхэ 6 нартай жэрмэсэн эхнэрые һамган болгожо абаба. Тэрэнь гурбан нара болоод хүбүү түрэбэ. Энэ хүбүүн **Зүлгүү** хаан гэжэ нэрэтэй байгаа, 1368 ондо хаан ширээдэ нуугаа... Энээнһээ хойшоо Хитадай хаадай уг залгамжалһаар 15 үе болобо. Мүнөө Дайцин хаанай үе. Тогоон Түмэр хаанай түрээ алдаһаар 276 жэл үнгэрбэ.

2.2 "Ёст хаан Юн Ло"-гийн домгийн түүхэн үндэс

⁸ *Erdeni-yin erike*, Öbür Mongyol-un Arad-un keblel-ün qoriyi-a, 1999, 152-153

⁹ *Altan erike*, Soyiji tuһan qaričaуulju tayiiburilaba, Öbür Mongyol-un Arad-un keblel-ün qoriyi-a 1991, 39-43

¹⁰ *Бурядад түүхэ бэшэгүүд*, Аюуша Саагиев (Сахьяев) Хори зоной ба хориин тайшаа ноёдой уг гарбал, тэдэнэй тоо тухай ураданай хаашуулай шастир туужануудһаа, домогуудһаа, үбгэдэй хэлсэдэг аман үгэнүүдһээ абтаһан хуряангы, Монгол хаашуулай домог, Россиин Наукануудай Академи Сибириин таһаг, Бурядад Эрдэмэй түб, Монгол Шэнжэлэлгын, Буддологи ба Тибетологин Эрдэмэй Институт, 2-дугаар ном, Найруулан зохёогшо Ш.Б.Чимитдоржиев, Харюусалгата редакторнууд Ш.Б.Чимитдоржиев, В.Ш.Гунгаров, Улаан-Үдэ, 1988, стр 7-8.

Энэхүү домог хэдийгээр уран сайхны өгүүллэг боловч Монголын Тогоонтөмөр, хятадын Мин улсын Юн Ло хаан зэрэг түүхэн бодит хүн эх дүр нь болж, Юан гүрэн мөхөн, монгол улсын төв эх нутагтаа дахин шилжсэн, Мин улсын төр тогтсон зэрэг түүхэн явдал уг домгийн үндэс болсон байна.

"Мин улсын хаан Юн Лэ (1403-1424)¹¹ монголыг таван удаа довтолж, монгол газар дайн хийж яваад нас нөхөцсөн. Монгол хатнаас гарсан хүн байсан учир монголтой байлдах аргаар сайн, моринд сайн хүн байсан гэдэг" (Далай, 1992:150, 191).

"Мин улсын эзэн хаад монголын эзэн хаадаас үүсэлтэй тэдний удам угсааг залгамжлагчид мөн гэж батлах зорилготой юм" (Пучковский, 1958), "Мин улсын хаадын дотроос Юн Ло монголыг ихэд сонирхон, монголын түүх судар түүний дотор "Монголын Нууц Товчоо"-ны эхийг хүртэл номын сандаа олж хадгалсан байсан нь сонирхолтой бөгөөд нэг учиртай байж ч магадгүй" (Гаадамба, 1977:172).

"Даймин улсын Юн Ло хааныг монголын ухаант хааны үлдээсэн хатнаас төрсөн хөвүүн хэмээдэг явдал монголын сурвалж бичигт нийтлэг тэмдэглэгдсэн байдаг. Энэ тухай аль эрт Иргэн улсын хориод оны үеэр хятадын эрдэмтэд шинжилгээний өгүүлэл нийтэлж, маргаан болж өнгөрчээ" хэмээн тэдгээр хятад хэлээр байгаа олон ном, өгүүллийн гарчгийг Чойжи (1984:552) эрдэмтэн Алтан товч номонд дурдан нийтэлжээ.

Энэ бүхэн нь ямар нэг түүхэн үндсийг баримталж, уг домгийг зохиосон гэдгийг нотолж байна. Уг домог эхлээд ард түмний дунд амаар хууч яриа, аман домгийн хэлбэртэй байсан бололтой байна. Улмаар түүхэн домог болгон хувирч баяжсаныг түүх зохиогчид боловсруулан, тодорхой үзэл санаанд зангидаж, монголын түүх бичлэгийн гол нэвтрэн гарах шугам, талархан дэмжсэн үзэл санаагаа тухайн цагийн хүмүүст (уншигчдад) хялбар ухагдах, таашаагдах шигтгээ болгон, түүхэн зохиолдоо ашигласан байна.

3. "Ёст хаан Юн Ло"-гийн домгийн аман хувилбаруудын тухай

А. "Юан тайж, Жин тайж хоёр" хэмээх аман домгийн гол өгүүлэмж:

1. Тогоон төмөр ханы үед иргэн айл тутам нэг лам сууж, шинэ бэр буулгахад урьдаар тэр ламтай нэг шөнө хоносоны дараа эр нь авдаг байжээ.
2. Иргэн хүнээс хүү төрвөл нум сум татаж чадахгүй болгох гэж баруун гарын эрхий хурууг тас чавчин авдаг байжээ.
3. Тиймд тэд монголын хаанд их мөнгөн бэлэг барьж, хүүхдийн хурууг чавчихгүй байхыг гуйна.

¹¹ Олонхи сурвалжид Юн Ло гэж бичсэн. Харин Ч.Далай академичийн номонд Юн Лэ гэж бичжээ. "Юн Лэ гэдэг бол хааны цол бөгөөд жинхэнэ нэр нь Чжу Ди, хааны цол нь Чэн-цзу юм. Гэвч монголын түүхэнд энэ хааныг оны цолоор нь голдуу нэрлэсэн учир тэр хэвээр бичив" (Далай, 1992, 191).

4. Хаан гурван сар дотор төрсөн хүүхдийн хурууг л чавчихгүй байхаар болов.
5. Тэр гурван сар дотор гарсан хүүхдийн дотор Жу Хун Эү (Zhu Hung Eu'), Ли Вэн Жин (Li Ven Zhing) зэрэг нэртэй хүмүүс төрнө.
6. Том болоод Хун Эү монголоор дарлуулж байсан өшөөгөө авахаар олонтой сэмээр хэлэлцэн тохирно.
7. Зургадугаар сарын шинийн зургааны шөнө тэмцэлд босон, захирсан лам нараа алахаар тогтно. Гэвч тэр өдөр амжсангүй.
8. Дахин 8 дугаар сарын арван тавны шөнө босож, монгол хүнийг алан, толгой, элгээр нь сар тахина.
9. Тэд Дайтүн (Dayitung) хотыг дайран, Тогоонтөмөр хааныг алахаар тогтно.
10. Энэ үед Тогоонтөмөр хаан жаргалдаа ташуурч, санаандгүй байжээ.
11. Тогоонтөмөр хаан их хатнаа дагуулан, тамгаан аваад, газар доогуур малтсан нүхээр зугатаана.
12. Жун Хун Эү хааны ордонд орж, Тогоонтөмөрийн бага хатны дүрс өнгөнд болж, эхнэрээ болгохоор шийднэ.
13. Тэр хааныг хөөж, нэг далайн зах дээр гүйцэн очтол тэнгэрээс нэг алтан хөлөг буугаад Тогоонтөмөр хаан суугаад явчихна.
14. Тогоонтөмөр хаан далайн цаадтай очиж, Барс хотыг байгуулаад хаан болж сууна.
15. Жу Хун Эү буцахдаа Тогоонтөмөр хааны замдаа ядраад тамгаа газар дээр тавьсан мөрийг нь олж, тамганых нь бичиг тал гарсаныг бичиж аван, түүнийг сийлж, тамгатай болоод Дайтүн хотод хаан болон сууна.
16. Жу Эү Хун Эүгийн хатан болгон авсан Тогоонтөмөр хааны бага хатан хоёр сар болсон давхар биетэй байжээ.
17. Хатан 12 сар болоод хүү төрүүлсэнд хааны шинжээч "их заяатай хүү байна гэж" гэж хэлээд Юан тайж гэж нэр өгнө.
18. Хоёр жилийн дараа тэр хатнаас бас нэг хүү төрөхөд хааны шинжээч "Энэ хүүгийн заяа ахдаа хүрэхгүй" гээд Жин тайж гэж нэр өгнө.
19. Тэр хоёр хүүгээ том болоход хатан эх нь хүнд өвчнөөр өвдөж, үхэхийн өмнө их хүүгээ дуудаж ирүүлээд хоёр дугтуйтай бичиг өгч, "зовох, жаргах цагтаа нээж үз" гэж өгөөд удалгүй үхнэ.
20. Хатныг үхсэний хойно нэг шөнө хаан "нэг цагаан эрээн могой бас нэг хар эрээн могой хоёр зодолдож, цагаан эрээн могой нь хар эрээн могойгоо хазаад алчих шахаад цагаан эрээн могой нь баруун талын өвдгийг нь түшиж, хар эрээн могой нь зүүн өвдгийг нь түшиж зарга мэдүүллээ" гэж зүүдэлнэ.
21. Хааны шинжээч надаас асуултгүй одоо даруй танд мэдэгднэ гэнэ.
22. Удалгүй хоёр хүү нь хоорондоо эвдрэлцэн орж ирээд их хүү нь баруун өвдгийг нь, бага хүү нь зүүн өвдгийг нь түшээд зарга мэдүүлнэ.
23. Хаан хоёуланг нь адилхан буруушаагаад гаргасны хойно их хүү нь монголын уг үндэс мөн байна гэж танина.
24. Их хүүг хаан алчихья гэж бодсон ч хар багаас нь хайрлан өсгөсөн тул чадалгүй монголын дайсан ирэх Нан Кеү(Nan Keu)-гийн амыг сахиулахаар явуулна. Тэгэхдээ Шар голын онгоцыг эхлэн татаж авчирчихаад тэр голыг гатлан гарч чадахгүй болохоор нь хааны цааз зөрчлөө гээд алья" гэнэ.

25. Тийнхүү монголын цэрэг ирэх Нан Кеү боомтыг 1000 цэрэг дагуулан хамгаалуулахаар явуулна.
26. Эхийн захиаг задлан уншвал тэрхүү боомтонд хөөгдөх цагт Лю Би Вэн түшмэлийг дагуул гэх мэтээр бичсэн байна.
27. Тийнхүү хүү заасан газар руу явж, бэрхшээл саадыг даван туулна.
28. Шидэт шувуу, эд зүйл хүн зэрэг түүнд тусална. Их хот барьж, түүнийгээ Бээжин гэж нэрлэн, Юан тайж бага хаан болж сууна.
29. Жу Хун Эү хаан түүнийг сонсоод монголоос сэрэмжлэн, Дайтун хотоос гарч, Нанжин (Nanzhing) руу явж, хэдэн жилийн дараа үхнэ.
30. Юан тайж эцгийнхээ нөхчиснийг сонсоод "эцгийнхээ хүүрт хүрч, цаас түлж, мөргөөд дүүдээ золгоё" гэж Бээжингээс Нанжин руу явна.
31. Эцгийн оронд хаан болсон Жин тайж ахыгаа гэнэт ирэх сургаар өшөө авч, хаан ширээг булаах нь гэж бодоод модноос боогоод үхнэ.
32. Ах нь их гашуудаж, дүүгээ оршуулчихаад Нанжингаас мордож, Бээжинд ирээд их хаан болон сууна.
33. Эх хатны жаргаж явахдаа үз гэсэн захиаг Юан тайж уншиж, монголын хааны уг үндэс гэдгээ мэдэн, монгол хүмүүст тустай зан үйл тогтоож, монгол лугаа дотуур элэгсэг явж байгаа тухай энэ үлгэрт өгүүлнэ.

Б.. "Юан тайшийн үлгэр" хэмээх аман хувилбарын гол өгүүлэмж

Энэ хувилбарын гол өгүүлэмж бичгийн хувилбартай болон аман А хувилбартай төстэй болно. Бусад хувилбарт байхгүй дүр, дүрслэл уг үлгэрт нэлээд байна.

Тогоонтөмөр хаан 32 жил Дайтун хотод хаан суусан. Тэр үед Жоу Хун Эү гэдэг хятадын шударга ноён байжээ. Тогоонтөмөр хааны 32 хятад жанжин нь урваж, монгол төрийг мөхөөхөөр 100 түмэн хятад цэргээр Дайтун хотыг гурван давхар бүслэв. Тэр үед Тогоонтөмөр хааны эцгийн үеийн Толин засаг жанжны хүү Томоот гэгч мэргэн түшмэл хаан, хааны эх хатан, хас эрдэнийн тамгыг авч, дагуулан явсаар эцгийн үед хэлж байсан Дайтун хотын дэргэдэх баруун уулын доор нэгэн хадны амаар орж, Монгол улсын наана хүрэх урт нүхээр дутаав. Хаан наян төө цаас нэвтлэх чадалтай эрдэнийн тамгаа хадан дээр дарж үлдээж гэнэ. Хятадын Жоу Хун Эү тэргүүтэй 500 цэрэг Тогоонтөмөр хааныг алахаар ирэхэд бага хатан нь сул хувцас өмсөж угтан, эхнэр нь болохоор гуйна. Тогоонтөмөр хааны хас эрдэнийн тамганы мөр нь гарсан нүхээр нь хятадын 500 цэрэг хөөсөөр монголын ногоот талд хүрвэл хаан тэргүүтэн гурван морь барьж унаад халуун зунаар их мөрнийг мөсөн дээгүүр явсан мэт гараад явчихав. Цэргүүд мөрөнг гатлах гэтэл ус нь мэлэлзэх тул гаталж үл чадна. Тогоонтөмөр хаан амар мэнд явсаар Эрилгийн цагаан тал гэдэг газар хааны хотыг барьж сууна. Жоу Хун Эү Тогоонтөмөрийн төрийг эзлэн, хаан сууж, бага хатныг нь авъя гэхэд түшмэд нь "дайсны нөхөр (эхнэр) байсан тул хэзээд дайсан болох тул битгий ав" гэж гэсэн боловч хаан үгэнд нь эс орно. Хатан бусад хувилбарт гардгийн нэгэн

адил жирэмсэн үлдсэн тул "шөнө болгон гадаа гарч, саранд залбиран, гэдсэн дэх хүүхдийн минь гарах сар, өдрийг уртасгаж хайрла!" хэмээн залбирна. Тэнгэр бурхан өршөөж, яг 13 сар дээр нь хүү гарна. Шинжээч заяаг нь үзээд " их буянтай хишигтэй хаан сууринд суух сайн хүү байна. Юан тайши гэж нэр өг гэнэ. Хятад түшмэл монголын хүү байх гэж баахан сэжиглэвч Жоу Хун Эү "Хүний хүүхэд есөн сар дээрээ гардаг. Би энэ хатныг аваад 10 сар дээр гарсан байхад яагаад миний хүү биш буй" гэнэ. Жоу Ху Эү Дайтунгаас Нанжин хотод шилжин сууна. Удалгүй бас монгол хатнаас нь хүү төрж, Жин тайши гэж нэрлэнэ. Хоёр хүү хоорондоо эв муутай өснө. Гэнэт хатан нь өвдөж, Юан тайшийг дуудан, -"Чи бол монголын хүү. Би чамайг саранд залбирч мөргөөд 13 (дахь) сар дээрээ гаргасан юм" гээд жаргах, зовох үедээ нээж үзээрэй гэж бичиг өгөөд үхнэ. Хаан бас цагаан эрээн могой, хар эрээн могой үүдний зүүн баруунаас гарч ирээд зодолдож, хар эрээн могой нь цагаан эрээн могойг алахад хүрэв гэж зүүдэлнэ. Өглөө нь Юан таши зүүн өвдгийг Жин тайши баруун өвдгийг нь түшин зарга мэдүүлэхэд хаан уурлан тэднийг явуулна. Ни зэрэг түшмэдтэйгээ зөвлөхөд Юан тайши бол монголын удмын, Жин тайши яах аргагүй хятадын үртэс мөн. Энэ бол хятад монголын тэмцэл мөн болно" гэж түшмэд хэлнэ.

Мөн А аман хувилбарын адил монголын цэрэг ирэх газрыг угтуулан Юан тайшийг цөлнө. Бусад үйл явдал дээрхи хувилбаруудын өгүүлэмжтэй адил өрнөж, үлгэрийн төгсгөлд Юан тайши хаан болон жарган сууж байгаагаар үлгэр төгснө. Энэ үлгэр бол ардын сайхан хэл найруулгатай, ярианы хэлний онцлог их хадгалсан, дүр, дүрслэл сайтай монгол ардын үлгэр болно.

3.1 Аман хувилбаруудын түүхэн үндэс

Эдгээр домог, үлгэрийн дүр нь анхаарал татаж байна. Бичгийн хувилбарт хятадын Хонхуа хаан 31 жил хаан суусан бөгөөд монгол удмын Юн Ло, хятад удмын Жахур-а гэдэг хоёр хүүтэй. Жахур-а хүү нь алагдаж, Хятад улс их хүүг нь Ёст хаан, Их Мин улсын Юн Ло хаан гэж өргөмжилнө.

Аман А хувилбарт хятад хүүхдийн баруун гарын эрхий хурууг тас чавчихаа түр 3 сар хориглосон үед төрсөн Жу Хун Эү хэмээх цэргийн жанжин хожим хятадын хаан болсон. Түүний хүү нь Юан тайж, Жин тайж гэдэг.

Аман Б хувилбарт Жоу Хун Эү гэдэг хятадын шударга ноён улмаар хаан болсон бөгөөд Юан тайши Жин тайши гэдэг хоёр хүүтэй байжээ гэж бичсэн. Эдгээр дүр нь түүхийн тусгал түүхт эх дүртэй байгаа нь сонин юм. Түүнээс бус Хун Эү гэдэг нь Мин улсыг үндэслэсэн хааны цол уу, нэр нь юм уу эсвэл Жахур-а гэдэг нэр нь Мин улсын анхны хаан Юн Ло-гийн төрсөн хүү юу, ач нь юмуу гэдэг маргаантай асуудлыг нотлох, дүгнэх нь аман зохиол судлалд гол бус харин түүхийн судлалын асуудал гэж бодож байна.

Эдгээр аман хувилбаруудад өмнө дурдсан бичгийн домгийн нэгэн адил Юан гүрний мөхөл, Тогоонтөмөр хааны монгол нутаг руугаа шилжин явсан тухай өгүүлжээ. Харин бичгийн дээрхи хувилбарт байхгүй

Тогоонтөмөр хааны төр хятад иргэдэд хатуу ширүүн хандаж байсан тухай дүрслэл тод гарч байна.

А хувилбарт Хятад 10 айл тутам нэг монгол лам сууж шинэ бэртэй эхлэн унтдаг”, Б хувилбарт Тогоонтөмөр хаан хятад хүнд их хатуу бас л арван хятад айлд цэрэг амбан суулгаж, хатуу хянадаг байсан тухай дурджээ.

Энэ нь Их Юаны хууль цаазын бичигт “орой бүрий, үүрийн харанхуйгаар хятад хүний хөл хорино. Хятад хүн анх удаа хэрэг хийвэл зүүн мөр дээр, хоёрдох удаад баруун мөр дээр, гуравдах удаад хүзүүн дээр шивээс тавина. Хятад хүн шорон гянданд суухдаа хоол хүнсээ өөрөө хариуцна. Хятад хүн зэр зэвсэг агуулах байтугай бор шувуу харвах чадвал хадгалж үл болно. Монгол хүн хятад хүнийг зодвол хариу өшөө авч болохгүй. Олон хүн цугларсан зах дэлгүүрийг зогсоох хятад хүнийг цэргийн эрдэмд үл сургах, жад шийдэм сургуулилах зэргийг цаазлан хориглож” эзлэгдсэн орны ард иргэдийн эрхийг хязгаарлаж байсан хатуу ширүүн хуулийн тусгал, уран сайхны дүрслэл болсон байна.

“Юан тайж, Жин тайж хоёр” домогт “иргэн хүн тэр цагт 8 дугаар сарын арван таванд монгол хүнээс хулгай хийж аваачин алаад толгой элгээр нь сар тахиж байсаныг” монгол удмаа мэдсэн Юан тайж тас зогсооё гэсэн боловч хятадыг монголчуудын зовоосон нь илүү их тул зөвхөн монгол хүнийг алж, тахилга хийлгэхийг байлгаад зөвхөн шийгуа, еэвэнгээр орлуулан, тахиx ёс тогтоосон гэж өгүүлнэ.

Энэ нь бас л “Юан гүрний үед 8 дугаар сарын арван таванд босч Татарыг алъя” гэдэг үгтэй бичгийг еэвэн дотор хийж хятад даяар тарааж, монголын эсрэг боссон юм. Иймээс хятадууд “еэвэн сарын баярыг 8 дугаар сарын 15-нд хийдэг” (Далай, 1992, 174) хэмээх түүхэн үйл явдал, зан үйлийн тусгал дээрх аман үлгэрт харагдаж байна.

Энэ мэтээр түүхэн хүн, түүхэн хэрэг явдал, хууль цааз, зан үйл тэр үеийн монгол, хятадын ард түмний хүсэл эрмэлзэл, тэмцэл, зөрчлийг тодорхой тусган зохиосон, нэг сэдэв, нийтлэг дүртэй, нэг үзэл, зорилго бүхий хувилбарууд байна.

3.2 Аман хувилбаруудын уран сайхан

Эдгээр аман хувилбарууд нь бичгийн хувилбараа бодвол илүү уран сэтгэмж, дүрслэлтэй, дэлгэрэнгүй өгүүлэмжтэй байна.

А хувилбарт Тогоонтөмөр хаан ордноосоо нууц нүхээр зугатан гарч явсныг хятадууд мэдэн хөөж гүйцтэл “тэнгэрээс нэг алтан хөлөг бууж ирээд аваад явчихна”. Энэ бол үнэхээр монгол шидэт үлгэрийн уран сэтгэмж бөгөөд гол баатрын хэрэг явдалд ид шидэт туслагч тусалж байна. Нөгөө талаар Тогоонтөмөр хаан бол тэнгэр язгуурт, Чингис хааны удам тул, хүнд хэцүү цагт дээд хөх тэнгэрээс ивээж байна гэсэн монгол үндэстний шүтлэг бишрэлийн сэтгэлгээ болон монгол шидэт үлгэр, баатарлаг туулийн дүрслэл болж чадсан байна.

Бичгийн хувилбарт Тогоонтөмөр хааны Хонкирад хатан нь гэдсэндээ гурван сар болсон хүүхэдтэй (А,Б аман хувилбарт) бага хатан нь жирэмсэн олзлогдоно. Б хувилбарт их хатан Тогоонтөмөр хаантай хамт зугатна. Бичгийн хувилбарт хатны нэр тодорхой байхад аман хувилбаруудад бага, их хатан хэмээн ерөнхий өгүүлсэн нь уг хоёр хувилбарын бичгийн болоод аман гэгдэх гол зарчмын ялгааг харуулж байна.

Аль ч хувилбарт нь тэнгэрт сүслэн залбирч, төрөлтийг хойшлуулж чадсан тухай мотив гарч байна. Б хувилбарт бол бүр тодорхой, жирэмсэн хатан "шөнө болгон гадаа гарч, саранд залбиран, гэдсэн дэхь хүүхдийг минь гарах сар, өдрийг уртасгаж хайрла" хэмээн залбирна. Энд сар бол хүүхдийг эвээн тэтгэгч гэж үздэг монголчуудын бөөгийн шүтлэгийн үзэл ойлголттой таарч байна. Ер нь хэн үнэн санаанаас бурхан, тэнгэрийг шүтэн, итгэж зэлбирч чадвал болохгүй бүтэшгүй зүйлийг ч энэ мэт өөрчлөн тусалж чадна гэсэн буддын, бөөгийн шашны ойлголтыг номлон итгүүлэх гэсэн үзэл санааг уран сэтгэмжээрээ дамжуулан илэрхийлсэн байна.

А хувилбарт монгол лам хүн хятад айлыг захиран суухдаа шинэ бэртэй энгэр зөрөн самуурч байсан мэт бичсэн нь лам хүний ёс журам, сахил санваар, бурханы номын ёстой зөрчилдсөн дүрслэл болжээ. Энэ нь уг хувилбарт нэлээд хожуу шарын шашны доройтоход, бурхан шашныг шүүмжлэх нийгмийн сэтгэл зүй их болсон үед жирийн эгэл ардаас нэмэн оруулсан дүр, дүрслэл байна. Гэхдээ энэ нь аман хувилбарын баяжуулалт, жирийн ард олны үзэл санааны чөлөөт байдлын дүрслэл болж чаджээ. Тэгвэл тодорхой үзэл санааг баримталсан, бурхан шашинд чин сүсэгтэй, тодорхой зохиогчийн туурвисан бичгийн зохиолд буддын шашны уг үндэс, номлол сургаалтай уг дүрслэл зөрчилдөх тул тийн андуу буруу бичихгүй нь мэдээж билээ.

Бичгийн хувилбарт хятад хаан "хоёр луу ноцолдож, зүүн талын луу дийлэв" хэмээн зүүдэлж байхад А аман хувилбарт "цагаан, эрээн хоёр могой зодолдож, цагаан эрээн нь хар эрээнээ хазаад алчих шахав" хэмээн зүүдэлнэ. Харин Б хувилбарт цагаан эрээн могой, хар эрээн могой үүдний зүүн, баруунаас гарч ирээд зодолдож, хар эрээн могой нь цагаан эрээн могойг алахад хүрэв" гэж зүүдэлнэ. Монгол аман хувилбаруудад ийнхүү луу биш могойг дүрсэлсэн нь учиртай юм.

Монголчуудын уламжлалт зан үйлийн сэтгэлгээгээр "могой бол тэнгэр, лусын элч төлөөлөгч, бэлэгдэл дүр. Ялангуяа хар юмуу хар эрээн могойг гэрт орох юмуу эвхэрсэн байх, зүүдлэгдэх нь гай барцад тохиолдох муу ёртой хэмээн үздэг" билээ.

Аман хувилбаруудад монголын удмын хүүг шууд алчихаж чадалгүй монголчуудын довтлон ирэх Нанькеү зэрэг боомт газрыг хамгаалуулж, монголыг монголоор нь сөнөөн устгах далд бодлогыг үлгэр, домог, дуулийн гол баатарт, хэцүү хүнд даалгавар өгөн сорих мотивт шилжүүлэн дүрсэлжээ. А хувилбарт хүүг явуулахдаа түүнд "хөгшин зөнөг нэг мянган цэрэг, эцэнхий туранхай нэг мянган морь, элэрхий балбархай нэг мянган зэвсэг", Б хувилбарт мөн "ядмаг хөгшин мянган цэрэг, яданги туранхай мянган морь, эвдэрхий хугархай мянган зэвсэг" өгч явуулж

байгаа нь ийм мотив "Гэсэр" зэрэг тууль болон монгол үлгэрт гардаг нэг гол мотив билээ. Харин Б хувилбарын мянган цэрэг нь хот суурин босгох үед цөм сайн мужаан байснаар дүрслэгдэнэ.

Энэ бүхэн нь бичгийн зохиолын бус харин ардын уран зохиолын амттай сайхан дүрслэл болж, аман хувилбарын чөлөөтэй дүрслэн үзүүлэх боломжийг илтгэж байна.

Аман А хувилбарт зургадугаар сарын аагим хуу халуунд голын ус дөрвөн хуруу хөлдөн, их цэрэг түүн дээгүүр гатлан гарч байгаа, нийслэл хотоос даган гарсан олон хөх шувуу харвахад нь ембүү болон, Б хувилбарт бас Тогоонтөмөр хаан халуун зунаар их мөрөн дээгүүр мөсөн дээгүүр гарсан юм шиг гараад явчихаж байгаа, дагаж явсан тагтаа шувууг харвахад нэг бүтэн ембүү болон газар унаж, цэргүүдийг өлсгөлөнгөөс аварч байгаа дүрслэл байна.

Хоёр аман хувилбарт адилхан "хар морь унасан, хар царайтай, хар жад барьсан" ид шидэт хүн гарч ирэн, тусална. А хувилбарт Юан тайж хар царайт хүний хэлснээр нум сум харваж, сум туссан газраасаа их эд, эрдэнэ олон, хар жадаа хатгасан газар нь "сарын тоогоор 12 их зээлтэй, одны тоогоор 28 их яамтай, жилийн хоногийн тоогоор 361 бага зээлтэй, 9 их хаалгатай Бээжин" гэж нэртэй хот бариад бага хаан болон сууж байгаагаар гарна.

Тэгвэл Б хувилбарт энэ мотив "улирлын тоогоор дөрвөн өнцөгтэй, одны тоогоор гурван зуун жаран нэгэн худагтай, жилийн тоогоор арван хоёр зээлтэй, одны тоогоор хорин яамтай хотыг байгуулж, хотын дунд алтан шар ордосыг байгуулан ордны дотор хас өндөр ширээг засаж, Бээжин хотыг барьж, төрийн бага хаан сууж байгаад улмаар Жин тайши дүү нь ордондоо боомилон үхсэн тул Юан тайши Дайтунаас Нанжин хотод төрийн их хаан болов гэж дүрсэлсэн. Энэ хэсэгт говь талын монголчуудын элбэг хангалууны уг үндэс нь одны тоогоор гурван зуун жаран нэгэн худагтай (Б хувилбарт) элбэг устай байх нь илүү зохистой дүрслэл болжээ. Эдгээр мотив дүрслэл нь монгол ардын баатарлаг тууль, бэнсний үлгэрийн баатарын орд харшийг нэг бүрчлэн тоочин магтан дуулах онцлог шинжийг хадгалж байна.

А хувилбарт эхийн гэрээслэн үлдээсэн захиаг зовох үедээ уншихад "Чиний бие Нанькеүгийн аманд хөөгдөх үед Лю Би Ван түшмэдийг дагуулан явах хэрэгтэй. Чи чухамдаа Тогоонтөмөр хааны хүү юм аа. Би гурван эрдэнэд залбирч даатгасаны хүчээр арван хоёр сар болоод төрсөн юм. Чи монгол хүнийг сэтгэлдээ бодож яв" гээд жаргах цагтаа үз хэмээсэн захианд "Чи чухам монголын хааны уг үндэс мөн. Чи эцэстээ их хааны суух цагт монголтой дотуур элэгсэг яв" гэжээ.

Б аман хувилбарт эхийн үлдээсэн хавтагыг нээж захиаг уншвал – "Чи хэзээ Нан ку забийн аманд цөлөгдөх үед Лю Взи Ван түшмэдийг дагуулан явах хэрэгтэй", жаргах үедээ "Чи хэдийгээр монголын хүү боловч эцэг Жоу Хун Эү үхэх үед заавал эргэж очих хэрэгтэй" гэж бичсэн байна.

Энэ мэт хэн нэгэн төрийн ухаант түшмэдийн дүр ч аман хувилбар бүрт байна. Монгол ардын аман үлгэр, туульд дайсны хүчинд автагдахдаа голомтныхоо чулуунд эсвэл тулганы доор захиа бичиг үлдээн, ёгт битүү далд утгаар үр хүүхдэдээ зам мөрийг нь заан өгдөг, сурган гэрээсэлдэг, захиа бичиг үлдээх мотив дээрхи аман хувилбаруудад уламжлагджээ. Ийнхүү монгол ардын аман зохиолын үндэсний онцлогийг харуулсан өвөрмөц олон мотив, чөлөөт уран дүрслэл тэдгээр аман хувилбар тус бүрд дүрслэгджээ.

4. Төгсгөл

"Ёст хаан Юн Логийн домог", "Юан тайж Жин тайж хоёр" (А хувилбар), "Юан тайшийн үлгэр" (Б хувилбар) хэмээх домог, үлгэр нь бичгийн ба аман хувилбараар тархсан, нэг сэдэв, нэг агуулга, үзэл санаа бүхий монгол зохиол байна. Бичгийн хувилбар нь монголын түүхэн сурвалжуудаар уламжлагдан, түүхэн үнэнг өгүүлэхэд бага зэрэг уран сэтгэмжтэй, уран сайхны шигтгээ, уянгын гажилт бүхий үүргээр орж, тодорхой үзэл санааг илэрхийлсэн байна. Энэ түүхэн домог тэр үеийнхээ "бусад домгийг бодвол эртний үг хэллэг, дүр дүрслэл багатай, ерийн өгүүлэлд ойр домог юм (Гаадамба, 1977, 172) гэж ч үздэг билээ. Харин аман хувилбарууд нь дэлгэрэнгүй өгүүлэмжтэй, уран сайхан дүрслэлтэй, ардын аман сонгодог бичгийн хэл найруулагатай, ордосын аман аялгуу үгсийн сангийн онцлогийг хадгалсан, биеэ даасан үлгэр, домог юмуу эсвэл Юан гүрний мандал бадралыг магтан дуулсан, мөхөл бутралыг нь эмзэглэн гэмшсэн эсвэл Тогоонтөмөр хааны намтар явдлын тухай өгүүлсэн баатарлаг тууль, бэнсний үлгэрийн хэсэг бүлгээс үлдсэн хэсэг байж ч магадгүй юм. Аман хувилбаруудад баатарлагийн тууль, домгийн гол баатрын ер бусын төрөлтийн мотив нь төрөлтийг хойшлуулах байдлаар, зүүд тайлах, зөн совин ёрын бэлгэдэл, шидэт үлгэрийн гол шинж болсон ид шидэт зүйл (эрдэнийн хас тамга, нум сум, жад, гол мөрөн аяндаа хөлдөн зам гарган туслах), ид шидэт амьтан (хөлөг морь, тагтаа, шувуу, луу, могой) ид шидэт хүн бус төрөлтөн (тэнгэр, сар, хар царайт хүн нь лус савдаг юмуу тэнгэрийн хүн бололтой) өргөн дүрслэгдсэн байна. Энэ нь монгол ардын аман зохиолын төрөл зүйлийн үүсэл, хоорондын зааг ялгаа, харилцан шилжин хувирах үзэгдэл зэргийг тогтоон ажиглахад тус болохоор байна. Уг хувилбарууд нь Ордос нутгаас олдсон нь санамсаргүй хэрэг биш юм. Чингис хааны найман цагаан ордон, туг сүлд, тахилга тайллагыг хадгалж байсан, Юан гүрний засаг төрийн ойр амьдарч, нутаглаж байсан Ордосын монголчуудын дунд энэ аман домог, үлгэр анх зохиогдон нэн олон хувилбараар хэдэн үе дамжин ирсэн нь тодорхой байна.

Энэ домог үлгэрийн хувилбарууд одоогийн Монгол улс, Буриад Монгол улс, Халимаг Тангач улсын ард түмний дунд хэр өргөн тархсаныг аман зохиолын хэрэглэгдэхүүнээс дахин нягталж, судлан тогтоох хэрэгтэй юм.

Summary

In his article R. Chultemsuren gives notable information on the legends of Yusu tu hagan Yun lo depicted in the historical books of ntobci, Cinggis hagan-u cadig, Lu. Altan tobci, Asaragci neretu teuke, Bolor etc. According to the

legend, during the fall of Yuan dynasty when Togooontumur Khan escapes from Peking to Mongolian territory taking with him many Mongolian followers and the Swastika Seal, queen Honkirad, pregnant with three months was left behind with the king of Min dynasty. The queen thinking that if her son born in 7 months would lead the king to believe the son of Mongolian king and would be killed immediately. But when born in the 10 months would make the king to believe his own son. The queen determined, prayed day and night and gives birth to a son in 13 months. The Chinese queen at the same time also gives birth to a son. One night, the king dreams about fight of two dragons. The dream was interpreted as the two dragons as conflicts between the Mongolian and Chinese sons. And the king makes his Mongolian son to reside out of his palace. The king Khun hua dies after 31 years of his reign. His Chinese son Jahur-a becomes the next king. The son of Mongolian heritage Yun Lo with the help of soldiers capture Jahur-a and takes his throne. The Chinese declares the traditional emperor as the ruler of Min dynasty who ruled for 22 years. In the book Altan tobci, his next 11 generation continued to rule the dynasty.

The legend lends us the facts that although Togooontumur Khan returned to his native land, the Yuan dynasty still existed at the time. Togooontumur Khan continued his reign in Mongolia. In other words the legend says that the descendants of Togooontumur for many generation had been ruler of Min dynasty. The legend was studied on historical ground by many scholars of Chinese historians, Russian scholar Palladi Kaparov, Chojji, of Inner Mongolia, China, Ch. Dalai, and on literature ground an oral literature researcher Sh. Gaadamba. And this article written by R. Chultemsuren provides study of the version of the legend comparing the above mentioned historical legend with oral tale of the legend. This oral tale is called Yuan taiji, and Jing taiji. The legend was collected from a place called A. Mostert Ordos. The other legend is called "Legend of Yuan taishi" .

The work is new in general, study done on comparing the two oral version of historical legend according to oral literature, and by oral and written literature. The oral version presents more detailed description, than the written one. The portrayal of the characters were impressive, showing specific significance of Mongolian oral literature.

Ном зүй

1. *Altan tobā, Šoyiji tulγan qaricayulju tayilburilaba, Öbür Mongγol-un Arad-un keblel-ün qoriyi-a*, 1983, 550-552.
2. Билигсайхан, Ч. *Монгол эрхи товчис*, УБ., 2000, 54-61
3. *Bimba-yin Asaraγā neretü(-yin) teüke*. Textological Study, Volume I, Transcription and index by Ts.Shagdarsureng, Lee Seon-Gyu, Edited by Choimaа, Ulaanbaatar, 2002, pp 44-45.
4. Гаадамба, Ш. (1977), Ёст хаан Юн Ло-гийн домог, *Монголын уран зохиолын тойм*, Хоёрдугаар дэвтэр, Редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд.
5. Гаадамба, Ш. Ёст хаан Ён-Логийн домог, *Монголын Нууц Товчооны судлалын зарим асуудал*, УБ., 1990, 188-190.
6. Болдбаатар, Ж., З.Понжид. (1999), *Монгол улсын түүх*, Түүх, онол арга зүйн асуудлууд, "Монголын түүхэнд Чингис хаан түүнийг залгамжлагчдын гүйцэтгэсэн үүрэг", УБ., 67-68.
7. Гонгор, Д. (1970) "Юан улсын үеийн Хархорум төвтэй уугуул монголчууд", *Халх товчоон*, УБ.,
8. Ишжамц, Н (1966) "XII зууны II хагас XIV зууны тэргүүн хагасын Юан улс", *БНМАУ-ын түүх*, Тэргүүн боть, Нэн эртнээс XVII зуун, УБ., 322-324
9. Далай, Ч. (1972), "Юан гүрний үеийн монголын түүхийн зарим асуудал", *Шинжлэх ухааны Академийн сэтгүүл*, №3, 6
10. Далай, Ч. (1975), *Юан гүрний үеийн монгол*, УБ.,
11. Далай, Ч. (1992), *Монголын түүх (1260-1388)*, Гудгаар дэвтэр, Редактор Н.Ишжамц, УБ.,
12. Дамдинсүрэн, А. *Монгол дөрвөлжин бичиг*, УБ., 1986.
13. Дорж, Б. (1990), "Юан гүрний гадаад харилцаанд холбогдох нэгэн баримт бичиг", *Түүхийн судлал*, Боть XXV, Дэвтэр 1-14, УБ., 1990, 37-41.
14. Жанчив, Е. *Дөрвөлжин үсгийн монгол дурсгалын хэлний судалгаа*, УБ., 2000
15. Лхагваа, Б. (1996) "Юан гүрэн Корёгийн харилцаа", "Юан гүрэн Жээжүүгийн холбогдох нь", *Монгол Солонгосын харилцааны уламжлалаас*, Сөүл хот, 1-210.
16. *Mongγol-un borjigid obuγ-un teüke*, Lomi jokiyaba, Nayusayinküü, Ardajab, Šoyiji tulγan qaricayulju tayilburilaba, Öbür Mongγol-un Arad-un keblel-ün qoriyi-a, 1989, 214-224.
17. Нацагдорж, Ш. (1966) "Юан улсын монгол орон", *БНМАУ-ын түүх*, Тэргүүн боть, Нэн эртнээс XVII зуун, УБ., 322-324.
18. Mingyada, Dүngsing jokiyaba, *Yuwan ulus-un degedü neyisiel Shangdu*, Öbür Mongγol-un Arad-un keblel-ün qoriyi-a, 2001, 1-204.

19. Төмөртоогоо, Д. *Монгол хэлний түүхэн хэл зүйн үндэс*, Монгол хэлний түүхэн авиан зүй, Нэгдүгээр дэвтэр, УБ., 1992.
20. Хишигтогтох(Ch. Keshigtogtohu), *Mongᠡᠯ-ᠤᠨ ᠡᠷᠡᠨ-ᠦ ᠤᠳᠠ-ᠠ ᠵᠠᠵᠢᠶ᠋ᠠᠯ-ᠤᠨ ᠰᠢᠨ-ᠡ ᠰᠤᠳᠤᠯᠤᠯ*, Yuwan ulus-un üy-e-yin ᠴoyijinodasar-un namtar teüke-yin tuᠻai dakin ögülekü-ni, Öbür Mongᠡᠯ-ᠤᠨ Arad-un keblel-ün qoriyi-a, 1984, 550-554. 1998.
21. Хүрэлбаатар, Л. *Монгол орчуулгын товчоон*, УБ., 1995, Монголын уран зохиолын дээжис, Сайн үгсийн сан, I боть, УБ., 1995.
22. Цэрэнсодном, Д. *XIY зууны үеийн яруу найрагч Чойжи-одсэр*, УБ., 1969.
23. Чулуунбаатар, Л. *Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл*, УБ., 2002, 84-97.
24. Чүлтэмсүрэн Р. Юан гүрний үед холбогдох нэгэн домгийн тухайд, *"Монгол судлал" (Mongolian Studies)*, The Korean Association for Mongol Studies, Seoul, 2003, 15, pp 157-179
25. Шагдарсүрэн, Ц. *Монгол үсэг зүй*, УБ., 1981, 10, Монголчуудын бичиг үсэг, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, Боть ХҮИ (169), УБ., 2001, 46-47.